



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 10 өдөр

Дугаар

A/183

Мандалговь

Уул уурхай, авто замын салбарт  
улсын үзлэг зохион байгуулах ажлын  
хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн улсын үзлэгийг уул уурхай, авто замын салбарт зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн дарга: Г.Хишигдаваа (Хөдөлмөр, Нийгмийн халамжийн үйлчилгээний газрын дарга)  
Нарийн бичгийн дарга: Э.Цэвэлмаа (Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөрийн хэлтсийн дарга)  
Гишүүд:  
Р.Лхагвадорж (Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)  
П.Нямсүрэн (Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч)  
И.Тогооч (Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч)  
Р.Цэрэндорж (Мэргэжлийн хяналтын газрын Геологи, уул уурхайн улсын байцаагч)  
О.Мөнхзул (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)  
П.Очирбат (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)  
Э.Цэрэннадмид (Мэргэжлийн хяналтын газрын барилга авто замын улсын байцаагч)

Хоёр. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн улсын үзлэгийг уул уурхай, авто замын салбарт 2020 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс 10 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулж, үр дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд тайлагнахыг ажлын хэсэг (Г.Хишигдаваа)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

482010505